

ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛСАН ИНД-157-Р ДҮРМИЙН ХАРЬЦУУЛАЛТ

<p align="center">АЭРОДРОМ БАЙГУУЛАХ, ӨӨРЧЛӨХ, НЭЭХ БА ХААХ (Шинэчлэгдэж байгаа) /7 хуудас/ 1996 оны NZ amend.1</p>	<p align="center">АЭРОДРОМ БАЙГУУЛАХ, ӨӨРЧЛӨХ, АШИГЛАЛТААС ХАСАХ (Хүчинтэй мөрдөгдөж байгаа) / 5 хуудас (үндсэн дүрэм-4 хуудастай байсан)/ 1996 оны NZ amend.1</p>	<p align="center">ТАЙЛБАР</p>
<p>157.1 Хамрах хүрээ</p> <p>(a) Энэ Дүрэм нь, энэ зүйлийн (b)-д заасан аэродром, эсхүл <u>хэлипорт</u> байгуулах, өөрчлөх, нээх, эсхүл хаахыг зорьж байгаа этгээдэд тавих шаардлагыг тогтооно.</p> <p>(b) Энэ Дүрэм нь дараахаас бусад аэродром, эсхүл <u>хэлипортод</u> хамаарна:</p> <p>(1) ИНД-139-ийн дагуу <u>гэрчилгээжсэн байхыг шаарддаг</u> аэродром; <u>эсхүл</u></p> <p>(2) үргэлжилсэн 30 хоногт 7-оос дээшгүй өдөр ашигладаг, <u>эсхүл ашиглахад зориулсан VFR-аар</u> үйл ажиллагаа нь хязгаарлагддаг аэродром, <u>эсхүл</u> хэлипорт; <u>эсхүл</u></p> <p>(3) ХАА-н агаарын хөлөг ашигладаг, эсхүл ашиглахад зориулсан нислэгийн хөдөлгөөний удирдлагын бүсэд байрлаагүй, дараах аэродром:</p> <p>(i) хамгийн ойр байрлах бусад аэродромоос 9 км-ээс (5 nm) багагүй зайд байрладаг;</p> <p>(ii) хамгийн ойр байрлах хэлипортоос 5.6 км-ээс (3 nm) багагүй зайд байрладаг; эсхүл</p> <p>(4) зөвхөн ХАА-н нисдэг тэрэг ашигладаг, эсхүл ашиглахад зориулсан нислэгийн хөдөлгөөний удирдлагын бүсэд байрлаагүй, дараах хэлипорт:</p> <p>(i) хамгийн ойр байрлах аэродромоос 5.6 км-ээс (3 nm) багагүй зайд байрладаг;</p> <p>(ii) хамгийн ойр байрлах бусад хэлипортоос <u>1.8 км</u>-ээс (1 nm) багагүй зайд байрладаг.</p>	<p>157.1 Зорилго</p> <p>(a) Аэродром болон вертодром шинээр барих, өөрчлөх, ашиглалтад оруулах, ашиглалтаас хасах ажлыг гүйцэтгэхэд тавигдах шаардлагыг энэ <u>дүрмээр</u> тогтооно.</p> <p>157.2 Үйлчлэх хүрээ</p> <p>(a) Энэ дүрэм нь, дараах аэродром болон <u>вертодромоос</u> бусад бүх аэродром болон вертодромд хамаарна:</p> <p>1/ ИНД-139-ийн дагуу <u>гэрчилгээжүүлэх</u> аэродром;</p> <p>2/ зөвхөн ил харааны нислэгийн дүрмээр, дараалсан 30 хоногийн дотор 7-гоос дээшгүй удаа ашиглах аэродром болон вертодром;</p> <p>3/ тухайн аэродромыг зөвхөн хөдөө аж ахуйн зориулалттай агаарын хөлөг хүлээн авахад ашигладаг буюу ашиглахаар төлөвлөж байгаа, түүнчлэн тухайн аэродром нь нислэгийн удирдлагатай бүсийн гадна оршдог ба:</p> <p>3.1 хамгийн ойр орших бусад аэродромоос 5 миль буюу 9 км-ээс багагүй зайд байрладаг;</p> <p>3.2 хамгийн ойр орших вертодромоос 3 миль буюу <u>6 км</u>-ээс багагүй зайд байрладаг;</p> <p>4/ тухайн вертодромыг зөвхөн хөдөө аж ахуйн зориулалттай агаарын хөлөг хүлээн авахад ашигладаг буюу ашиглахаар төлөвлөж байгаа, түүнчлэн <u>вертодром</u> нь нислэгийн удирдлагатай бүсийн гадна оршдог ба:</p> <p>4.1 хамгийн ойр орших аэродромоос 3 миль буюу 6 км-ээс багагүй зайд байрладаг;</p> <p>4.2 хамгийн ойр орших вертодромоос 1 миль буюу <u>2 км</u>-ээс багагүй зайд байрладаг.</p>	<p>-Хамрах хүрээнд багтсан</p> <p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>-Вертодромыг “хэлипорт” болгож өөрчилсөн</p> <p>-“3 миль буюу 6 км” гэснийг “5.6км-ээс (3nm)” гэж өөрчилсөн</p>

<p>157.3 Нэр томьёо ба товчлол <u>Энэ Дүрэмтэй холбоотой нэр томьёо болон товчлол нь ИНД-ийн нэр томьёоны тайлбарт багтсан.</u> <u>Энэ Дүрмийн 157.1 болон 157.5-ын зорилгоор аэродромд нисдэг тэрэг ашиглахад тусгайлан зориулсан, эсхүл бүтээсэн, газар, эсхүл усан дээр тогтоосон талбай багтахгүй.</u></p>	<p>157.3 Тодорхойлолт</p>	<p>-Нэр томьёоны тайлбар ИНД-1-д орсон</p>
<p><u>157.5. Мэдэгдэл хийх шаардлагатай төсөл</u></p> <p>Дараах төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа этгээд нь (цаашид Хүсэлт гаргагч гэх) 157.7-д заасан хэлбэрээр Даргад зорилгын мэдэгдэл хүргүүлнэ:</p> <p>(1) энэ Дүрэм хамаарах аэродром, <u>эсхүл</u> хэлипортыг байгуулах, <u>эсхүл бусад хэлбэрээр бий болгох, эсхүл ийм аэродром, эсхүл хэлипортыг ажиллуулах;</u></p> <p>(2) <u>энэ Дүрэм хамаарах</u> аэродром, эсхүл хэлипортын хөөрч буух зурвас, <u>эсхүл бусад агаарын хөлгийн</u> хөөрөлт, эсхүл буултын талбайг байгуулах, чиглэл өөрчлөх, өөрчлөх, эсхүл ажилд оруулах;</p> <p>(3) зөвхөн VFR-аар үйл ажиллагаа нь хязгаарлагддаг аэродром, <u>эсхүл</u> хэлипортыг үргэлжилсэн 30 хоногт 7-оос дээш хоногоор ашиглахаар сунгах;</p> <p>(4) энэ Дүрэм хамаарах аэродром, эсхүл хэлипортыг, эсхүл тухайн <u>аэродром, эсхүл хэлипортын хөөрөлт, эсхүл буултын талбайг</u> нэг жил, эсхүл түүнээс дээш хугацаагаар хаах, ашиглалтыг зогсоох, эсхүл татгалзах.</p>	<p>157.5 <u>Ерөнхий шаардлага</u></p> <p>(а) Дараах аль нэг ажлыг гүйцэтгэхээр төлөвлөж буй этгээд /цаашид Өргөдөл гаргагч гэх/ нь энэ дүрмийн 157.7-д заасны дагуу өргөдөл гаргаж ИНЕГ-ын даргад ирүүлнэ:</p> <p>1/ энэ дүрэмд хамаарах аэродром <u>болон вертодромыг</u> шинээр барих, эсхүл <u>ашиглалтыг сэргээх</u> бол;</p> <p>2/ аэродром <u>болон</u> вертодромын хөөрч буух зурвас, талбайг шинээр байгуулах, эсхүл ашиглалтыг нь сэргээх, чиглэлийг нь өөрчлөх бол;</p> <p>3/ зөвхөн ил харааны нислэгийн дүрмээр ашиглагддаг аэродром <u>болон</u> вертодромын ашиглалтыг дараалсан 30 хоногийн дотор 7-гоос дээш удаа ашиглахаар сунгах бол;</p> <p>4/ энэ дүрмийн дагуу ашиглаж буй аэродром болон вертодромыг нэг жил буюу түүнээс дээш хугацаагаар татан буулгах, ашиглалтыг түр, эсхүл бүрмөсөн зогсоох бол.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>-“вертодром” гэснийг “хэлипорт” гэж өөрчилсөн</p>

157.7 Зорилгын мэдэгдэл

- (a) Энэ дүрмийн 157.5 (1), (2) болон (3)-т шаардсан мэдэгдлийг, тухайн ажил эхлэх өдрөөс 90-ээс доошгүй хоногийн өмнө САА 24157/01 маягтын дагуу Даргад хүргүүлсэн байна.
- (b) Энэ дүрмийн 157.5(4)-т шаардсан мэдэгдлийг тухайн аэродромыг хаах, ашиглалтыг зогсоох, эсхүл татгалзахаар төлөвлөсөн өдрөөс 30-аас доошгүй хоногийн өмнө бичгээр хүргүүлсэн байна.

157.9 Нисэхийн судалгаа

(a) Дарга 157.7(a)-ийн дагуу зорилгын мэдэгдэл хүлээн авсны дараа, нисэхийн судалгаа хийнэ.

(b) Дарга нисэхийн судалгааг хийхдээ хамааралтай гэж үзсэн иргэд, төлөөллийн бүлэг болон байгууллагатай зөвлөлдөнө.

(c) Нисэхийн судалгааг санал болгосон ажиллагаа нь агаарын зайд агаарын хөлгийг аюулгүй, үр ашигтай ашиглах болон газарт байгаа хүн, өмч хөрөнгийн аюулгүй байдалд үзүүлэх нөлөөллийг тодорхойлох зорилгоор хийнэ. Тодорхой нөхцөлд нисэхийн судалгаанд дараах хүчин зүйлийг анхаарч үзнэ:

- (1) санал болгосон ажиллагаа нь одоо байгаа, эсхүл шинээр төлөвлөж байгаа аэродром, хөрш аэродромын хөдөлгөөний хайрцагт хэрхэн нөлөөлөх;
- (2) санал болгосон ажиллагаа нь, одоо байгаа болон төлөвлөж байгаа агаарын зайд хэрхэн нөлөөлөх;
- (3) санал болгосон ажиллагаа нь газарт байгаа хүн болон өмч хөрөнгийн аюулгүй байдалд хэрхэн нөлөөлөх;
- (4) холбогдох газар нутагт одоо байгаа, эсхүл хүний гараар бүтээхээр санал болгосон объект болон байгалийн объект нь санал болгосон ажиллагаанд хэрхэн нөлөөлөх.

157.7 Өргөдөл гаргах

- (a) Энэ дүрмийн 157.5-ын 1/, 2/, 3/-т заасан ажлыг гүйцэтгэх тухай өргөдлийг, тухайн ажлыг эхлэхээр төлөвлөсөн өдрөөс 90 хоногийн өмнө ИНЕГ-ын даргад ирүүлнэ.
- (b) Энэ дүрмийн 157.7-ын 4/-т заасан ажлыг гүйцэтгэх тухай өргөдлийг аэродром татан буулгах, ашиглалтыг түр болон бүрмөсөн зогсоохоор товлосон өдрөөс 30-аас доошгүй хоногийн өмнө ИНЕГ-т ирүүлнэ.

157.9 Аэродромын судалгаа хийх

(a) Энэ дүрмийн 157.7-гийн (a)-д заасны дагуу ирүүлсэн өргөдлийг хүлээн авмагц ИНЕГ-ын дарга Аэродромын судалгаа хийх ажлын хэсгийг томилно.

(b) Аэродромын судалгаагаар дараах зүйлүүдийг тогтооно:

- 1/ шинээр байгуулах буюу ашиглах аэродром нь, түүний ойролцоо орших ашиглагдаж байгаа аэродромын үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлөх;
- 2/ шинээр байгуулах буюу ашиглах аэродром нь одоо болон ирээдүйд агаарын зайн ашиглалтад хэрхэн нөлөөлөх;
- 3/ шинээр байгуулах буюу ашиглах аэродром нь аэродромын аюулгүй ажиллагаа болон зорчигч, өмч хөрөнгийн аюулгүй байдлыг хангахад хэрхэн нөлөөлөх;
- 4/ аэродромын үйл ажиллагаа, баригдсан буюу барихаар төлөвлөж буй барилга байгууламж нь хүрээлэн буй орчинд хэрхэн нөлөөлөх.

-Орчуулга,
найруулга зассан

-Орчуулга,
найруулга зассан

-“Aeronautical study”-
аэродромын
судалгаа гэснийг
“нисэхийн судалгаа”
болгож өөрчилсөн

157.11 Аэродромын талаарх шийдвэр

(a) Нисэхийн судалгаа дууссаны дараа Дарга хүсэлт гаргагч, холбогдох орон нутгийн удирдлага болон бусад сонирхогч этгээдэд аэродромын талаар дараах аль нэг шийдвэрийг гаргаж өгнө:

(1) **Татгалзах зүйлгүй:** санал болгосон ажиллагаа нь агаарын зайд агаарын хөлгийг аюулгүй, үр ашигтай ашиглах болон газарт байгаа хүн, өмч хөрөнгийн аюулгүй байдал, хүрээлэн буй орчинд сөргөөр нөлөөлөхгүй гэж үзвэл Дарга “татгалзах зүйлгүй” гэсэн шийдвэр гаргана;

(2) **Нөхцөл заасан:** санал болгосон ажиллагааны хүлээн авах боломжгүй хүчин зүйлийг тогтоон, хэрэв тодорхой заасан нөхцөлийг дагаж мөрдсөн тохиолдолд, санал болгосон ажиллагаа нь агаарын зайд агаарын хөлгийг аюулгүй, үр ашигтай ашиглах газарт байгаа хүн, өмч хөрөнгийн аюулгүй байдал болон хүрээлэн буй орчинд сөргөөр нөлөөлөхгүй гэж үзвэл Дарга “нөхцөл заасан” шийдвэр гаргана;

(3) **Хүлээн авах боломжгүй:** Дарга санал болгосон ажиллагааг хүлээн авах боломжгүй шалтгааныг тогтоовол “хүлээн авах боломжгүй” гэсэн шийдвэр гаргах ба шалтгааныг тодорхой заана.

(b) Нислэг үйлдэх агаарын зайн ашиглалтын оновчтой төлөвлөлтийг хялбаршуулах зорилгоор хүлээн авах боломжгүй болон нөхцөл заасан аэродромын талаарх шийдвэрт хүчингүй болох хугацааг тодорхой заана.

(c) Энэ Дүрэмд шаардсан мэдэгдэл гаргах шаардлагатай бүх ажил, эсхүл ажиллагааг тухайн шийдвэрт заасан хугацаанд багтаан хэрэгжүүлж дууссан байна. Аливаа хэлбэрээр сунгасан, өөрчилсөн, эсхүл цуцалснаас бусад тохиолдолд, аэродромын талаарх шийдвэр нь заагдсан өдөр хүчингүй болно.

(d) **Сонирхсон этгээд** шийдвэрийн хүчингүй болох хугацаанаас 15-аас доошгүй хоногийн өмнө Даргад дараах хүсэлтийг

157.11 Дүгнэлт, шийдвэр

(a) ИНЕГ-ын дарга, Аэродромын судалгааг хийж дуусмагц аэродромын талаар дүгнэлт гаргаж өргөдөл гаргагч, холбогдох орон нутгийн захиргааны байгууллага болон сонирхсон бусад этгээдэд танилцуулсны дараа дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:

1/ **Зөвшөөрсөн шийдвэр** : Агаарын зайг оновчтойгоор ашиглаж, аэродромын аюулгүй ажиллагаа болон зорчигч, өмч хөрөнгийн аюулгүй байдлыг бүрэн хангаж, хүрээлэн буй орчинд ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй гэдэг нь үзлэг шалгалтаар нотлогдсон тохиолдолд ИНЕГ-ын дарга "Зөвшөөрсөн" шийдвэр гаргана;

2/ **Нөхцөл заасан шийдвэр:** Зарим нэг зүйлийг засаж залруулах арга хэмжээ авсны дараа агаарын зайг оновчтойгоор ашиглаж, аэродромын аюулгүй ажиллагаа болон зорчигч, өмч хөрөнгийн аюулгүй байдлыг бүрэн хангаж, хүрээлэн буй орчинд ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй гэж үзсэн тохиолдолд ИНЕГ-ын дарга "Нөхцөл заасан" шийдвэр гаргана;

3/ **Татгалзсан шийдвэр:** өргөдөл гаргагчийн шинээр байгуулах буюу ашиглахаар хүсэлт гаргасан аэродром нь шаардлага хангахгүй болох нь судалгаагаар тогтоогдсон бол ИНЕГ-ын дарга "Татгалзсан" шийдвэр гаргана.

(b) Нислэгийн хөдөлгөөний удирдлагатай агаарын зайн ашиглалтыг оновчтой төлөвлөх зорилгоор Нөхцөлт ба Татгалзсан шийдвэрт уг дүгнэлтийг эргэн хянах өдрийг тодорхой заасан байна.

(в) Өргөдөл гаргагч нь энэ зүйлийн (б)-д заасан хугацаа дуусахаас 15-аас доошгүй хоногийн өмнө ИНЕГ-ын

-“Аэродромын судалгаа” гэснийг “Нисэхийн судалгаа” гэж өөрчилсөн

-Орхигдуулсан заалтыг нэмж оруулсан

<p>гаргаж болно:</p> <p>(1) тухайн шийдвэр гаргасан үндэслэлийг өөрчлөх шинэ баримтад тулгуурлан шийдвэрийг дахин авч үзэх; эсхүл</p> <p>(2) шийдвэрийн үйлчлэх хугацааг сунгах.</p>	<p>даргад дараах өргөдлийг гаргаж болно:</p> <p>1/ шийдвэр гаргахад нөлөөлсөн зүйлүүдийг засаж залруулсан учир дүгнэлтийг эргэн хянахыг хүссэн өргөдөл; эсхүл</p> <p>2/ шийдвэрт заасан хугацааг сунгахыг хүссэн өргөдөл.</p>	
<p>157.13 Гүйцэтгэлийн талаарх мэдэгдэл</p> <p>Энэ дүрмийн 157.5-ын дагуу хийгдсэн ажлын гүйцэтгэлийг хамаарал бүхий этгээд тухайн ажиллагаа дууссанаас хойш 15 хоногийн дотор Даргад бичгээр гүйцэтгэлийн талаар мэдэгдэнэ.</p>	<p>157.13 Ажлын гүйцэтгэлийн талаар мэдэгдэх</p> <p>(a) Аливаа этгээд энэ дүрмийн 157.5-д заасан аль нэг ажлыг хийж гүйцэтгэснээс хойш 15 хоногийн дотор ажлын гүйцэтгэлийн тайланг ИНЕГ-ын даргад бичгээр ирүүлнэ.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p>

Дүрмийн боловсруулалтын хэлтэс